УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

НИЙГМИЙН ОНОО ТООЦОХ СИСТЕМ БҮХИЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/215

Захиалагч: УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар

Хянасан: ПСХХ-ийн захирал Д.Бумдарь (Ph.D.)

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн хэлтсийн дарга Ц.Норовдондог (Ph.D.)

Судлаачид: Р.Оргилмаа, О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл

Улаанбаатар хот, 2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ
НЭГ. НИЙГМИЙН ОНОО БУЮУ НИЙГМИЙН РЕЙТИНГ
ХОЁР. НИЙГМИЙН ОНОО ТООЦОХ СИСТЕМ БҮХИЙ УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА
2.1.БНХАУ
2.2.ХБНГУ
2.3.ИБУИНХУ
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас ирүүлсэн захиалгын дагуу “Нийгмийн оноо тооцох систем бүхий гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд хийж гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гадаадын зарим орны иргэд, байгууллагын түвшинд нийгмийн оноо болон нийгмийн рейтинг тогтоодог туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд БНХАУ (Хятад), ХБНГУ (Герман), ИБУИНХУ (Их Британи) зэрэг орнуудын нийгмийн онооны системийн тухай, түүнийг ашигладаг салбар, тооцдог аргачлалын талаарх практик туршлага болон холбогдох эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн болно.

Судалгааны бүтэц: Судалгаа нь хураангуй болон судалгааны дэлгэрэнгүй хэсгээс бүрдэнэ. Судалгааны дэлгэрэнгүй хэсэгт нийгмийн онооны суурь ойлголт, хэлбэр ба онцлог, нийгмийн онооны системийн ажиллах зарчим, давуу болон сул талууд, нийгмийн оноо тооцох системийг нэвтрүүлсэн орнуудын туршлагыг хамруулав.

Түлхүүр үг: *Нийгмийн онооны систем, нийгмийн рейтинг тогтоох*

Key words: *Social score, social rating*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхийн зарим улс орнууд нийгмийн амар амгалан байдлыг сахин хамгаалах, иргэдийн үүрэг, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор нийгмийн онооны систем буюу иргэдийг бүртгэлжүүлэх, тэдний үйл ажиллагааг хянах, үнэлгээ өгөх, зэрэглэл тогтоох системийг бий болгон, хэрэгжүүлж байна. Нийгмийн онооны систем нь нийгмийн үнэт зүйл, хэм хэмжээнд үндэслэн, эерэг зан үйлийг дэмжин, урамшуулах замаар нийгмийн үйл ажиллагааг хянах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зан үйлийг төлөвшүүлэх зорилготой.

Гэвч судалгаанаас үзэхэд ихэнх улс оронд эхэндээ нийгмийн онооны системийг банк санхүүгийн салбарт зээлийн эрсдэлээс сэргийлэх, иргэдийн санхүүгийн чадавхыг тодорхойлох зорилгоор ашиглаж ирсэн байдаг.

Анх 1959 онд үндэс суурь нь тавигдсан АНУ-ын FICO score (Fair Isaac Corporation score) буюу зээлдэгчийн зээлээ эргэн төлөх магадлалыг үнэлдэг эрсдэлийн үнэлгээний системийг дэлхийн 100 гаруй оронд хэрэгжүүлж байгаа ба Монгол улс энэхүү системийг банкны салбартаа нэвтрүүлээд удаагүй байна.

Судалгаанд авагдсан орнуудын хувьд нийгмийн онооны системийг банк, санхүүгийн салбартаа түлхүү ашиглахын сацуу, түүнийг хэрэгжүүлэх зорилго, хэрэгжүүлж буй салбар зэрэг нь тухайн улсын түүхэн уламжлал, ёс заншил, онцлог, түүнчлэн төрийн тогтолцоо зэргээс хамаарч харилцан адилгүй байна. Зарим нэг орон, тухайлбал, БНХАУ-ын хувьд нийгмийн онооны тогтолцоог үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн, хувь хүн, төрийн болон бизнесийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглаж байгаа нь онцлог байна. Харин бусад улс орнуудын хувьд хязгаарлагдмал хүрээнд тодорхой салбарт авч хэрэгжүүлж байгаа нь нийтлэг ажиглагдаж байна.

Хятад улс нийгмийн онооны системийг 2009 оноос орон нутагт, 2014 оноос үндэсний хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн ба уг асуудлыг зохицуулах хуулийн төслийг өргөн барьсан боловч одоогоор батлагдаагүй байна. Судалгаанд авагдсан бусад орнуудын хувьд (Герман, Их Британи) мөн нийгмийн онооны системийн бие даасан хуульгүй бөгөөд нийгмийн оноо олгох, зэрэглэл тогтоох системтэй холбоотой аливаа харилцааг нийгмийн онооны системийг хэрэгжүүлж буй тухайн салбарын, хувь хүний болон байгууллагын нууцын, мэдээллийн технологийн аюулгүй байдлын тухай зэрэг холбогдох хуулиудаар зохицуулдаг байна.

Судалгаанаас үзэхэд, улс орнууд нь нийгмийн онооны системд технологийн дэвшлийг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд иргэдийг бүртгэлжүүлэх (зарим улсад хүн ам зүйн болон биеийн давхцахгүй өгөгдөл болох хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч зэрэг мэдээллийг агуулсан), мэдээллийн их өгөгдлийн сан (big data) үүсгэж, хиймэл оюун ухааны тусламжтайгаар алгоритмын аргаар оноог тооцдог байна.

Хятад улсын хувьд нийгмийн онооны тусламжтайгаар төрийн хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд улс даяар 600 сая гаруй царай таних хяналтын камер байрлуулан иргэдийн өдөр тутмын үйлдлийг хянахын сацуу онлайн орчинд ч мөн иргэдээ хянадаг байна. Ийнхүү хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглаж иргэдээ хянаж байгаа асуудал нь зарим талаар шүүмжлэл дагуулж байна. Тухайлбал, хувь хүн болон байгууллагын мэдээллийн нууц алдагдах, ижил, төстэй царай төрх болон овог нэртэй хүмүүсийн мэдээлэл давхардах, мэдээллийг тогтмол шинэчлээгүйн улмаас гэмгүй иргэд шийтгэл хүлээх, хохирох тохиолдлууд цөөнгүй гардаг байна.

БНХАУ-д нийгмийн оноо тооцох, зэрэглэл тогтоох системийг хэрэгжүүлэх явцад хүний салшгүй эрх болон бусад эрхүүд зөрчигдөх тохиолдлууд нэлээдгүй гарч байгааг олон улсын хүний эрхийн байгууллагууд хэлж тэмцсээр байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээс

бусад тохиолдолд нийгмийн онооонд үндэслэн энгийн иргэдийн аялах, ажилд орох, тодорхой үйлчилгээнд хамрагдах зэрэг үйл ажиллагаанд хориг тавьж, шийтгэл ногдуулж байгаа нь хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж байна гэж үздэг. Түүгээр ч зогсохгүй эцэг, эхийнхээ нийгмийн онооноос шалтгаалан үр хүүхэд нь хүссэн сургуульдаа элсэн суралцах эрхээ хасуулсан тохиолдол хүртэл гарч байсан байна Нийгмийн оноо тааруу хүнтэй хөрш зэргэлдээ амьдрах нь тухайн хүний нийгмийн онооонд нөлөөлөх тохиолдлууд авторитар дэглэмтэй Хятад болон ардчилсан засаглалтай Герман, Их Британи зэрэг орнуудын аль алинд гарч байгаа нь хэт туйлширсан шийдвэр гаргах, хүний эрхийг зөрчих сул талтай байна.

Улс орнууд нийгмийн онооны системийг зөв нэвтрүүлж чадвал нийгэмд ил тод байдлыг бий болгож, эрх баригчдыг хянах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, иргэдтэйгээ шударга харилцах хандлагыг бий болгох бөгөөд хууль сахиулах үйл ажиллагаанд тодорхой ахиц гарч, хуулийн хэрэгжилт сайжрах зэрэг эерэг өөрчлөлтүүд гарахыг үгүйсгэхгүй гэж зарим судлаачид үзэж байна.

Гэвч нийгмийн оноо олгох, зэрэглэл тогтоох системийг хэрэгжүүлэх явцад хүний салшгүй эрхүүд зөрчигдөж байна гэж олон улсын хүний эрхийн байгууллагууд үзэж байна. Тухайлбал, “Human Rights Watch”, “Интернэт орчинд хүний эрхийг хамгаалах” (La Quadrature du Net), Европын Дижитал эрх (European Digital Rights) зэрэг хүний эрхийн байгууллагуудаас Европын Зөвлөл болон Европын Парламентад хандан Европын Холбоонд мөрдөж буй Хиймэл оюун ухааны тухай хууль (AI Act)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хамтарсан санал гаргаж, мэдэгдэл хийсэн байна.

Хиймэл оюун ухаанд суурилсан нийгмийн онооны систем нь хүмүүсийн хувийн нууцад халдаж, нийгмийн халамж хүртэх эрхийг үндэслэлгүй хязгаарлаж, амьжиргааны түвшингээр нь хүмүүсийг ангилж, ялгаварлан гадуурхаж байгаа бөгөөд энэ нь иргэдийн орон сууц, хоол хүнс худалдан авах, амьжиргаагаа залгуулах хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна гээд Хиймэл оюун ухаанд суурилсан нийгмийн онооны системийн тархалтыг таслан зогсоохыг шаардсан байна. Франц улсад ашиглаж буй гэр бүлийн тэтгэмжийн сан (CAF) болон төрийн бусад байгууллага, татварын байгууллагуудын өөрсдийн боловсруулан ашиглаж буй үнэлгээний систем, Нидерланд улсын Засгийн газраас боловсруулсан, иргэдийн ажил эрхлэлт, орон байрны бүртгэл, тэтгэмж болон зээлийн талаарх мэдээлэл, төрийн байгууллагуудад хадгалагдаж буй хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг ашигладаг эрсдэлийн үнэлгээний систем (SyRI), Австри улсын Засгийн газраас хувь хүний ажил эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах боломжийг хянадаг бүртгэл, онооны систем зэрэг нь иргэдийн нийгмийн хамгааллыг хүртэх, хувийн нууцаа хамгаалуулах, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг зөрчин, эрсдэлд оруулж байна гэж үзсэн байна

Судалгаанд авагдсан улс орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Хятад улс нь нийгмийн зэрэглэл тогтоох, нийгмийн оноо олгох системийг үндэсний хэмжээнд төр, нийгэм, эдийн засгийн бүх салбартаа хэрэгжүүлж байгаа бөгөөд улс орон даяар иргэд төдийгүй байгууллага, аж ахуйн нэгжүүд, түүнчлэн тус улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниудыг бүртгэлжүүлэн, хяналт тавьж байна. Зорилго нь нийгэм дэх бүх субьектуудын найдвартай, тогтвортой байдлыг үнэлэх оноо олгож, эерэг зан үйл, үйлдлийг урамшуулах, тааруу үнэлгээ авсан тохиолдолд хар жагсаалтанд бүртгэж шийтгэл ногдуулахад чиглэдэг гэсэн байна. Шийтгэлийн төрөлд тодорхой үйл ажиллагаанд хориг тавих, байгууллага, аж ахуйн нэгжийн хяналт шалгалтыг нэмэгдүүлэх, доголдолтой үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, эрхийг цуцлах зэрэг шийтгэлүүд хамаарч байна.

Герман улс нь Хятадын нийгмийн онооны систем болон АНУ-ын FICO системтэй зарим талаараа төстэй зээлийн үнэлгээний “SCHUFA” системийг хэрэгжүүлж байна. Уг системийг хариуцдаг компани нь 67 сая гаруй иргэн, 5 сая компанийн мэдээллийг агуулсан, зээлдэгч болон зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зээлжих чадварыг үнэлэхэд туслах, мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй хувийн компани юм. Германы энэхүү систем, түүнд үндэслэн шийдвэр гаргах эрхийг бүхэлд нь хувийн компаниудад олгохыг зөвшөөрсөн нь олон нийтийн дунд эргэлзээ төрүүлж, оноог бүр ч тодорхой бус болгож байна гэх шүүмжлэл дагуулдаг байна.

Германд байр түрээслэх, худалдан авах, зээл авах, зээлээр бараа авахад “SCHUFA” оноог зайлшгүй шаарддаг. Санхүүгийн болон өндөр итгэлцэл шаардагдах ажилд ороход зарим тохиолдолд мөн “SCHUFA” онооны тайланг шаарддаг байна. Зээлийн оноо өндөр байх нь зээлийн хүү буурахад нөлөөлдөг бол зээлийн оноо бага байх нь зээлийн хүүг нэмэгдүүлэх эсвэл бүр зээлийн хүсэлтээс татгалзахад хүргэдэг. Иймд зээлдэгчид төлбөрөө хугацаанд нь хийж, зээлийн оноогоо сайн байлгах шаардлагатай болдог. SCHUFA-ийн үйлчилгээ нь Европын Мэдээлэл хамгааллын ерөнхий журам (GDPR) болон Холбооны Улсын мэдээллийн хамгаалалтын хууль (BDSG)-ийн хүрээнд явагддаг бөгөөд бүртгэлийн сангийн мэдээллээ 3 жил тутам шинэчилдэг байна.

Түүнчлэн эрүүл амьдралын хэв маягийг дэмжих бодлогын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын компаниуд дасгал хөдөлгөөнийг хянах апликейшнаар дамжуулан даатгалын шимтгэлийг бууруулах нөхцөлтэйгөөр иргэдийг хянах, урамшуулахад ашигладаг байна.

Их Британид иргэдийн зээлийн чадварыг үнэлэх зорилгоор оноо өгөх зээлийн үнэлгээний системийг ихэвчлэн банк санхүүгийн болон худалдаа үйлчилгээний салбарт хэрэгжүүлж байна. Зээлийн оноо нь тухайн хүний зээлжих чадварын тоон илэрхийлэл бөгөөд зээлдүүлэгчид санхүүгийн найдвартай байдлын талаарх мэдээллийг өгдөг. Зээлийн оноог хэд хэдэн элементүүдийг ашиглан тооцдог бөгөөд зээлийн онооны чухал бүрэлдэхүүн хэсэг нь зээлийн данс, төлбөрийг цаг тухайд нь төлсөн эсэх төлбөрийн түүх, зээлийн ашиглалт, зээлийн данс эзэмшсэн хугацаа буюу зээлийн түүх, ашиглаж буй зээлийн төрлүүд болон шинээр авсан зээлийн мэдээлэл зэргээс бүрддэг. Зээлийн оноо нь орон сууц түрээслэх, нийтийн үйлчилгээний гэрээ байгуулах гэх мэт тодорхой үйлчилгээнд хамрагдахад нөлөөлдөг байна. Зээлийн оноо өндөр байх нь зээлийн хүү буурах, олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг байна.

Австрали улс нь тус улсад ажиллаж, амьдрахаар ирсэн цагаач иргэдэд “тусгай ангиллын виз” (special category visa) олгодог байна. Тус визийг авахын тулд “зөв зан чанар” тест (good character test)-ийг бөглөн, шалгуулдаг. Тэнцээгүй тохиолдолд Австрали улсаас албадан гаргах нөхцөл болдог байна. Их Британи, Шинэ Зеланд зэрэг улсууд үүнтэй адилаар тодорхой шалгуурыг хангасан цагаач иргэдийг хилээр нэвтрүүлж, босго оноо тавьдаг байна.

Тус улсад мөн өрх толгойлсон эхчүүдэд зориулсан “Ирээдүйн эцэг эх” (ParentsNext) халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрт хамрагдаж, мөнгөн тусламж авахын тулд өрх толгойлсон эхчүүд долоо хоног бүр хүүхдээ усанд сэлэлтийн хичээлд хамруулах, номын сангаар хамтдаа зочлох зэрэг хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжилд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэн, биелэлтийг баталгаажуулах шаардлагатай болдог.

Израил улс нь эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлын системийн нэг хэсэг болгон агаарын тээврээр зорчигчдод код олгох системийг ашигладаг байна. Энэ нь АНУ-ын Холбооны мөрдөх товчооны Террористыг илрүүлэх төвөөс хөтөлдөг, илэрсэн болон сэжиглэгдсэн террористуудын мэдээллийн сангийн нэг хэсэг “Агаарын тээврээр зорчихыг хориглосон хүмүүсийн жагсаалт” (No Fly List)-тай адил байна. Энэ нь хэдийгээр болзошгүй аюулаас

урьдчилан сэргийлэх зорилготой ч тус жагсаалтад бүртгэлтэй гэмт хэрэгнүүдтэй ижил нэр, овог, царай төрх бүхий энгийн иргэд жагсаалтанд давхар бүртгэгдэх, шийтгэгдэх зэрэг тохиолдлууд нэлээдгүй гардаг байна.

Энэтхэг улс нь иргэдийг бүртгэлжүүлэх “Aadhaar” хөтөлбөрийг 2009 оноос хэрэгжүүлсэн бөгөөд тус улсад оршин суугч иргэн бүрд 12 оронтой тоо бүхий дугаар олгон, хүн ам зүйн болон биеийн давхцахгүй өгөгдөл болох хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч зэргийг багтаасан бүртгэл, мэдээллийн сан үүсгэсэн байна. Тус санд нийт хүн амын 99 хувийн мэдээллийг бүртгэлжүүлээд байна. Анхандаа зорилтот иргэдийг халамжийн хөтөлбөрт хамруулах зорилгоор үүсгэсэн тус мэдээллийн санг хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах болсон байна. Гэвч арилжааны зорилгоор хууль бусаар мэдээллийн санд нэвтрэх оролдлогууд гарсаар байгааг мэдээлэлд дурджээ.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. НИЙГМИЙН ОНОО БУЮУ НИЙГМИЙН РЕЙТИНГ

Нийгмийн оноо тооцох, нийгмийн зэрэглэл тогтоох систем нь шинээр бий болсон ойлголт биш бөгөөд хүмүүсийг нийгэмд эзлэх байр суурь, гарал үүсэл, эд хөрөнгө, ах дүү, төрөл төрөгсөд, боловсрол зэргээр нь ангилах явдал улс орон бүрд байсаар байсан. Нийгмийн оноо, түүнтэй ижил төстэй, иргэд болон албан байгууллага, тодорхой бүлгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэн, оноо өгөх системийг ихэвчлэн эдийн засгийг сайжруулах, санхүүгийн зээлжих чадварыг нэмэгдүүлэх үүднээс хэрэгжүүлж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн байгууллагууд анхлан иргэдийн нийгмийн сүлжээний мэдээллийг ашиглан төлбөрийн эрсдэлээс сэргийлэх боломжийг олж харсан бөгөөд тухайн хүний хүрээлэл, харилцдаг хүмүүс зэрэг мэдээлэлд үндэслэн үнэлгээ өгч, зээл олгох эсэхээ шийдвэрлэж байсан байна.

Өнөөгийн харилцан уялдаа холбоотой техник, технологийн эринд нийгмийн зэрэглэл тогтоох сустемийг янз бүрийн түвшинд, янз бүрийн зорилгоор ашиглаж байна. Нийгмийн зэрэглэл тогтоох систем нь хүн ам зүйн болон зан төлвийн ижил төстэй өгөдлүүдийг ашиглахын сацуу интернэт, онлайн нийгмийн сүлжээ бий болсноор төрөл бүрийн мэдээллийн эх сурвалж, нарийвчилсан техник, хэрэгсэл, технологийн дэвшил-хиймэл оюун ухаан зэргийг ашиглан иргэдийн нийгэм дэх байр суурийг онлайн орчноор дамжуулан тодорхойлох болсон байна. Төрийн болон хувийн секторын аль алинд нь нийгмийн зэрэглэл тогтоох системийг хүний зан төлвийг тодорхой хэлбэрт оруулж ангилсан, дижитал хяналтын хэлбэрээр ашиглаж байна.

Нийгмийн онооны системийн тогтсон загвар гэж байхгүй бөгөөд, улс орнууд харилцан адилгүй хэлбэр, онцлог бүхий тогтолцоог туршин, ашиглаж байна. Өөрийн улсын онцлог, иргэдийн зан төлвөөс хамааран улс орнууд нийгмийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлгээ өгөх энэ төрлийн системийг хууль сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх, иргэдийн ёс зүйтэй байх, бусдын эрхийг хүндэтгэн биеэ зөв зүйтэй авч явах, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сайжруулах хийгээд бусад зорилгоор, харилцан адилгүй хэлбэрээр хэрэгжүүлж байна.

АНУ-д иргэдийг зээлээ эргэн төлөх чадвараар нь эрэмбэлдэг зээлийн үнэлгээний агентлагууд ажилладаг байна. Тухайлбал, 1959 онд байгуулагдсан FICO корпорац нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн түгээмэл ашигладаг FICO Score-зээлдэгчийн зээлээ эргэн төлөх магадлалыг үнэлдэг эрсдэлийн үнэлгээний аргачлалыг нэвтрүүлсэн байна. 1989 оноос хэрэглээний зээлийн эрсдэлийн стандарт хэмжүүрээр АНУ-д хүлээн зөвшөөрөгдсөн тус зээлийн онооны загварыг дэлхийн 100 гаруй улс өөрийн улсын онцлогт нийцүүлэн ашигладаг бөгөөд FICO Score нь зээлдэгчийн эрсдэлийг 300-850 оноогоор үнэлэн, тухайн хүний зээлийн талаарх буюу өмнө нь зээлтэй эсэх, зээлийн хэмжээ, юунд зарцуулсан болон зээлээ цагт нь төлдөг эсэх зэрэг бүрэн мэдээллийг өгдөг байна.

Австрали улс нь тус улсад ажиллаж, амьдрахаар ирсэн цагаач иргэдэд “тусгай ангиллын виз” (special category visa) олгодог байна. Тус визийг авахын тулд “зөв зан чанар” тест (good character test)-ийг бөглөн, шалгуулдаг. Тэнцээгүй тохиолдолд Австрали улсаас албадан гаргах нөхцөл болдог байна. Их Британи, Шинэ Зеланд зэрэг улсууд үүнтэй адилаар тодорхой шалгуурыг хангасан цагаач иргэдийг хилээр нэвтрүүлж, босго оноо тавьдаг байна.

Дарвин хотын зөвлөл иргэдийн гар утасны мэдээллээс хүмүүсийн хөдөлгөөнийг бүртгэн тэмдэглэх технологийг туршиж үзсэн байна. Хяналтын камерууд зүй бус хөдөлгөөн хийсэн

хүнийг тодорхойлж, Хяналтын төвд дохио өгөн, цаашлаад Цагдаад мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авах боломжтой байна.

Тус улсад мөн өрх толгойлсон эхчүүдэд зориулсан “Ирээдүйн эцэг эх” (ParentsNext) халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрт хамрагдаж, мөнгөн тусламж авахын тулд өрх толгойлсон эхчүүд долоо хоног бүр хүүхдээ усанд сэлэлтийн хичээлд хамруулах, номын сангаар хамтдаа зочлох зэрэг хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжилд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэн, биелэлтийг баталгаажуулах шаардлагатай байна.

Израил улс нь эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлын системийн нэг хэсэг болгон агаарын тээврээр зорчигчдод код олгох системийг ашигладаг байна. Энэ нь АНУ-ын Холбооны мөрдөх товчооны Террористыг илрүүлэх төвөөс хөтөлдөг, илэрсэн болон сэжиглэгдсэн террористуудын мэдээллийн сангийн нэг хэсэг “Агаарын тээврээр зорчихыг хориглосон хүмүүсийн жагсаалт” (No Fly List)-тай адил байна. Энэ нь хэдийгээр болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилготой ч тус жагсаалтад бүртгэлтэй гэмт хэрэгнүүдтэй ижил нэр, овог, царай төрх бүхий энгийн иргэд жагсаалтанд давхар бүртгэгдэх, шийтгэгдэх зэрэг тохиолдлууд нэлээдгүй гардаг байна.

Хятад улс нийгмийн онооны тогтолцоог үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн, хувь хүн, төрийн болон бизнесийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, суурь оноо олгон, оноог нэмэгдүүлэх болон хорогдуулах байдлаар урамшуулах хийгээд шийтгэл ногдуулдаг байна.

Энэтхэг улс нь иргэдийг бүртгэлжүүлэх “Aadhaar” хөтөлбөрийг 2009 оноос хэрэгжүүлсэн бөгөөд тус улсад оршин суугч иргэн бүрд 12 оронтой тоо бүхий дугаар олгон, хүн ам зүйн болон биеийн давхцахгүй өгөгдөл болох хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч зэргийг багтаасан бүртгэл, мэдээллийн сан үүсгэсэн байна. Тус санд нийт хүн амын 99 хувийн мэдээллийг бүртгэлжүүлээд байна. Анхандаа зорилтот иргэдийг халамжийн хөтөлбөрт хамруулах зорилгоор үүсгэсэн тус мэдээллийн санг хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах болсон байна. Харин арилжааны зорилгоор хууль бусаар мэдээллийн санд нэвтрэх оролдлогууд гарах болжээ.

Нийгмийн оноо болон хүний эрх

Нийгмийн амгалан тайван байдлыг сахин хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон бусад зорилгоор хэрэгжүүлж буй нийгмийн оноо олгон, зэрэглэл тогтоох систем, нийгмийн оноонд суурилан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зарим талаар хүний эрхийг ноцтой зөрчиж байгаа тухай ардчилсан зарчмыг баримтлагч улс орнууд, хүний эрхийн байгууллагууд, олон нийт эсэргүүцлээ илэрхийлдэг байна.

Олон улсад хүний эрхийг хамгаалсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт баримт бичгүүдэд дурдсан,

1. Ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах;
2. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
3. Чөлөөтэй зорчих;
4. Хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах хүний салшгүй эрхүүд нь нийгмийн онооны системийг хэрэгжүүлж буй зарим улс орнуудад тодорхой хэмжээгээр зөрчигдөж байна хэмээн үзэж байгаа ажээ.

Ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах эрх нь хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байснаар, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүн өөрийн сонгосон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан ямар ч төрлийн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхээ эдэлснээр, чөлөөтэй зорчих эрх нь хүн бүр улс орныхоо дотор чөлөөтэй зорчих, амьдран суух газраа сонгох эрхээр тус тус баталгаажна. Цаашлаад хүн ямар ч улсыг, түүн дотор өөрийн улсыг орхин явах эрхтэй байна. Хүн өөрт хамааралтай нууцыг хамгаалуулснаар халдашгүй байдал нь баталгаажих хэдий ч бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахин хамгаалах, нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор хувь хүний дээр дурдсан эрхүүдийг хязгаарлахыг зөвшөөрдөг байна.

Харин нийгмийн оноо олгох, зэрэглэл тогтоох системийг хэрэгжүүлэх явцад хүний салшгүй эрхүүд зөрчигдөх тохиолдлууд нэлээдгүй гарч байгааг олон улсын хүний эрхийн төлөө тэмцэгч байгууллагууд тэмдэглэсээр байна. Тухайлбал, 2023 оны 10 дугаар сарын байдлаар “Human Rights Watch”, “Интернэт орчинд хүний эрхийг хамгаалах” (La Quadrature du Net), Европын Дижитал эрх (European Digital Rights) хүний эрхийн байгууллагуудаас Европын Зөвлөл болон Европын Парламентад хандан Европын Холбоонд мөрдөж буй Хиймэл оюун ухааны тухай хууль (AI Act)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хамтарсан саналаа илэрхийлж, мэдэгдэл хийсэн байна.

Хиймэл оюун ухаанд суурилсан нийгмийн онооны систем нь хүмүүсийн хувийн нууцад халдаж, нийгмийн халамж хүртэх эрхийг үндэслэлгүй хязгаарлаж, ядуурлын талаарх хэвшмэл ойлголтод тулгуурлан хүмүүсийг ангилж, ялгаварлан гадуурхаж байгаа бөгөөд энэ нь иргэдийн орон сууц, хоол хүнс худалдан авах, амьжиргаагаа залгуулахад хүндрэл учруулж байна гээд Хиймэл оюун ухаанд суурилсан нийгмийн онооны системийн тархалтыг таслан зогсоохыг шаардсан байна. Франц улсад ашиглаж буй гэр бүлийн тэтгэмжийн сан (CAF) болон төрийн бусад байгууллага, татварын байгууллагуудын өөрсдийн боловсруулан ашиглаж буй үнэлгээний систем, Нидерланд улсын Засгийн газраас боловсруулсан, иргэдийн ажил эрхлэлт, орон байрны бүртгэл, тэтгэмж болон зээлийн талаарх мэдээлэл, төрийн байгууллагуудад хадгалагдаж буй хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг ашигладаг эрсдэлийн үнэлгээний систем (SyRI), Австри улсын Засгийн газраас хувь хүний ажил эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах боломжийг хянадаг бүртгэл, онооны систем зэрэг нь иргэдийн нийгмийн хамгааллыг хүртэх, хувийн нууцаа хамгаалуулах, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг зөрчин, эрсдэлд оруулж байна гэж үзсэн байна.

ХОЁР. НИЙГМИЙН ОНОО ТООЦОХ СИСТЕМ БҮХИЙ УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

2.1. БНХАУ

БНХАУ-ын Нийгмийн оноо (Social credit score) буюу Хятадын зэрэглэл тогтоох систем (China’s ranking system) нь Хятадын нийгэм дэх итгэлцлийн хэмжүүрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн улс орон, хүн амыг бүхэлд нь хамарсан мэдээллийн цогц бүртгэл бөгөөд үүний үндсэн дээр хяналтыг хэрэгжүүлдэг байна. Нийгмийн оноог хувь хүн, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдэд олгодог байна. Нийгмийн онооны системийг анх 2009 оноос орон нутагт туршиж эхэлсэн бөгөөд 2014 онд албан ёсоор зарлан, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн байна. 2022 оны байдлаар Хятад улсын хот, муж, бүс нутгийн 80% гаруй нь Нийгмийн онооны системд хамрагдсан байна.

Нийгмийн оноо нь томоохон банк, санхүүгийн байгууллагууд хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн зээлийн чадварыг тодорхойлон, түүнд үндэслэн алдагдалгүй, зөв шийдвэр гаргах зорилгоор тухайн этгээдийн талаарх мэдээллийг ашиглаж эхэлсэн бөгөөд хуулийг дагаж мөрдөж байгаа эсэх зэрэг бүртгэл мэдээллийг нэмэлтээр оруулан, хувь хүн болон байгууллагад олгосон тодорхой оноог нэмэгдүүлэх болон хорогдуулах болсон байна.

Тааруу нийгмийн оноо нь ноцтой үр дагаварт хүргэж болно. Аливаа зөрчил гарган оноогоо хасуулсан хувь хүмүүс нь аялах, ажилд орох, зээл авах, гэрээ байгуулах зэрэг нийгмийн үйлчилгээ хүртэх эрхээ хасуулан шийтгүүлдэг бол эерэг нийгмийн оноо нь бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөнгөвчлөх зэрэг таатай боломжуудыг олгодог байна.

Хятад улс даяар хэрэгжүүлж буй цахим нэгдсэн системийн бүртгэл нь дүн шинжилгээ хийх үйл явцыг хурдасгаж, хамгийн гол нь хяналтыг хөнгөвчилж байна гэж тус улсын эрх баригчид үзэж байна.

Хэрэгжүүлэгч байгууллагууд

БНХАУ-ын төрийн эрх барих дээд байгууллага болох Төрийн Зөвлөл, түүний харьяа Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо нь нийгмийн онооны тогтолцоо, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Тус хороо нь Төрийн Зөвлөлд ажлаа хариуцан тайлагнадаг, макро-эдийн засгийн бодлогыг тодорхойлогч байгууллага юм. Хятадын Ардын банк нь мөн нийгмийн онооны тогтолцоонд бодлогын голлох байр суурь эзэлдэг байна.

Төв засгийн газрын харьяа салбарын асуудал хариуцсан агентлагууд нь нийгмийн онооны тогтолцоонд тодорхой үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд ялангуяа хар болон улаан жагсаалтын тэмдэглэлийг хөтөлдөг байна. Тухайлбал, Тээврийн яам, Соёл, аялал жуулчлалын яам, Хятадын Ардын банк зэрэг болно. Ардын Дээд шүүх мөн өртэй хүмүүсийн хар жагсаалтыг хөтөлдөг байна.

Бүс, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь нийгмийн онооны тогтолцооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд голлох үүрэг бүхий байгууллагууд бөгөөд 2017 онд “жишиг хотууд” санаачлагыг хэрэгжүүлсэн байна.

Хэд хэдэн хувийн компаниуд өөрсдийн онооны системийг бий болгон ашиглаж байгаа бөгөөд улсын хэмжээнд ашиглаж буй нийгмийн онооны тогтолцоонд сайн дурын үндсэн дээр оролцох боломжтой байна. Эдгээрийн заримыг бие даан боловсруулсан бол заримыг засгийн газраас туршилтын журмаар хамтран боловсруулсан байна. Түүнчлэн зарим хувийн компаниуд засгийн газартай гэрээ байгуулан, нийгмийн онооны системийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дэд бүтцээр хангах байдлаар ажилладаг байна.

Итгэлцлийг нэмэгдүүлэх замаар нийгмийн оноо нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорьсон. Үүнд:

Санхүүгийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх
Ихэнх улс орнуудад ашиглагддаг зээлийн төлбөрийн чадварын талаарх үнэлгээ нь Хятадын санхүү, бизнесийн салбарт шаардлагатай бөгөөд нийгмийн оноо нь тус мэдээллийг олгох зорилготой байна.

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх
Нийгмийн онооны системийг хэрэгжүүлснээр хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх шинэ механизмыг бий болгоно гэж үзсэн.

Худалдаа, арилжааны найдвартай байдлыг нэмэгдүүлэх
Худалдаа, арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд болон арилжааны үйл ажиллагаанд оролцогч талуудыг хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, залилантай тэмцэх механизмыг сайжруулна гэж үзсэн.

Нийгэм дэх итгэлцлийг нэмэгдүүлэх
Үнэнч шударга, шаргуу хөдөлмөрч, гэр бүлээ дээдэлсэн хувь хүний эерэг үйлдлийг дэмжин ёс суртахуунтай нийгмийг цогцлооно гэж үзсэн.

Засгийн газрын үйл ажиллагааны ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх
Төрийн захиргааны удирдах албан тушаалтнууд болон улс төрчдийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж авлигыг бууруулна гэж үзсэн.

Дээрх зорилтуудыг гурван үндсэн арга замаар хэрэгжүүлнэ гэж үзсэн байна. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах болон хуваалцах
  Нийгмийн онооны системийн суурь үндэс нь мэдээлэл юм. Тус системээр дамжуулан төв, бүс, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагууд мэдээлэл цуглуулж, цуглуулсан мэдээллээ хоорондоо солилцон ашигладаг байна. Тухайн цугларсан мэдээллийг “Их өгөгдлийн сан”-д бүртгэж, боловсруулан ашигладаг байна.
- Хар жагсаалт болон улаан жагсаалтаар ангилах
  Хувь хүн болон байгууллагууд (төрийн болон хувийн)-ын талаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн хар болон улаан жагсаалтад хуваарилдаг байна.
- Шийтгэл болон урамшуулал
  Цуглуулсан мэдээллийн тодорхой хэсэг дээр үндэслэн хувь хүмүүс болон байгууллага, аж ахуйн нэгжийг урамшуулах хийгээд шийтгэл ногдуулдаг байна.

“Dang’an” буюу Хятад дахь хувь хүнтэй холбоотой багц бүртгэл мэдээлэл нь хувь хүний үйл ажиллагаа, биеэ авч яваа байдал болон тухайн хүний биеийн харагдах байдал, гэрэл зураг, сурлагын тэмдэглэл, ажил эрхлэлтийн байдал, шагнал урамшуулал, захиргааны шийтгэл, гэмт хэрэгт холбогдсон байдал зэрэг мэдээллийг багтаасан байдаг. Энэхүү мэдээллийг насан туршид нь шинэчлэн, 2 хувь хадгалдаг байна. Нэгийг Олон нийтийн аюулгүй байдлын товчоонд, нөгөөг тухайн этгээдийн ажлын байран дээр хадгалдаг байна. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн албан тушаал дэвшүүлэх зэрэг хувь хүний ажил, амьдралд нөлөөлөх гол шийдвэрүүдийг гаргадаг байна.

Нийгмийн онооны систем нь мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хувь хүмүүст оноо өгдөг байна. Оноог тоогоор (1-1000 хүртэл) болон үсгээр (A-D хүртэл) орлуулан олгодог. Мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд зэрэг олон эх сурвалжаас бүрдүүлдэг байна. Ихэнх тохиолдолд төвлөрсөн мэдээллийн санд хандан эрх бүхий байгууллагууд шаардлагатай мэдээллийг авч ашиглах боломжтой байна. Харин зарим мэдээлэл нь зөвхөн тодорхой бүс, орон нутгийн, эсхүл төв засгийн газрын эрх бүхий байгууллага хандах боломжтой байдаг байна.

Төрийн байгууллагыг үнэлэх

Байгууллага, аж ахуйн нэгжийг үнэлэхдээ төрийн албан байгууллагыг мөн үнэлдэг бөгөөд 2020 оны байдлаар торгууль, шийтгэлийн 13.3%-ийг төрийн албан байгууллагуудад ногдуулсан байна. Нийгмийн онооны систем нь засгийн газрын харьяа агентлагуудын үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын ажлын гүйцэтгэл, түүн дотор санхүүгийн асуудлууд, өр зээл болон гэрээний зөрчил зэрэгт онцгой хяналт тавьдаг байна.

Аж ахуйн нэгжийг үнэлэх

Хятад улсад иргэдийн үйлдлийг хянан, үнэлгээ өгөхийн сацуу бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд түлхүү хяналт тавьдаг байна. Хятад улс даяар үйл ажиллагаа явуулж буй дотоод болон гадаадын аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэн, хяналт тавьж, үнэлгээ өгөх зорилготой аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн онооны систем нь аж ахуйн нэгжүүдийн хуульд нийцсэн байдал, санхүүгийн болон аудитын мэдээлэл зэргийг харгалзан үнэлгээ өгдөг байна. Одоогийн байдлаар Хятад улс даяар үйл

ажиллагаа явуулж буй 33 сая гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэн, үнэлгээ өгөөд байна. Үндэсний, бүс, орон нутгийн хэмжээний болон тодорхой салбаруудад суурилсан мэдээллийн санг ашигладаг байна.


Аж ахуйн нэгжүүдийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалздаг. Үүнд:

- Тухайн аж ахуйн нэгж татвараа хугацаанд нь төлсөн эсэх;
- Үйл ажиллагааныхаа чиглэлээр шаардлагатай зөвшөөрөл авсан эсэх;
- Үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцэж байгаа эсэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь чанарын стандарт хангаж буй эсэх;
- Эрхэлж буй үйл ажиллагаа нь тухайн салбарын үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг хангаж буй эсэх зэрэг болно.

Аж ахуйн нэгжүүдэд олгож буй оноо нь тухайн аж ахуйн нэгжийн хамтрагч байгууллагын үйл ажиллагаанаас хамааран буурах магадлалтай тул хамтрагч байгууллагаа сонгохдоо нэлээд нухацтай хандах шаардлагатай байна.

“CreditChina” Хятадын үндэсний мэдээллийн санд хувь хүн болон аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг нэгтгэн төвлөрүүлж байгаа бөгөөд дараах мэдээллийг авах боломжтой байна. Үүнд:

- **Үндсэн мэдээлэл,** аж ахуйн нэгжийн хувьд нийгмийн онооны бүртгэлийн дугаар болон үйл ажиллагааны зөвшөөрөл;
- **Захиргааны шийтгэл** хүлээж байсан эсэх;
- Шүүхээс ногдуулсан **Төлбөрийн үлдэгдэл** бий эсэх;
- **Татвараас зайлсхийх, залилан мэхлэх** аливаа тохиолдол байсан эсэх;
- **Хууль бус импорт болон экспорт**ын мэдээлэл;
- **Цалин хөлс олгоогүй** тохиолдол бий эсэх зэрэг болно.



Нийгмийн онооны Хар жагсаалт (Blacklist)

Хятад улсад өнөөгийн байдлаар олон тооны үндэсний болон бүсийн хэмжээний хар жагсаалтууд тэмдэглэгдэн, хадгалагдаж байгаа бөгөөд эдгээрийг ойрын хугацаанд нийгмийн онооны системтэй бүрэн нэгтгэх төлөвлөгөөтэй байна. Хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас аж ахуйн нэгжүүд нийгмийн оноогоо хасуулдаг байна. Зөрчил гаргасан аж ахуйн нэгжүүдийг зөрчлөөс нь хамааран Зөрчлийн жагсаалт (Irregularity list) болон Хар жагсаалтанд бүртгэдэг бөгөөд зэрэглэлийн хувьд ноцтойд тооцохооргүй бол Зөрчлийн жагсаалтанд бүртгэдэг байна. Хэрэв зөрчлийн жагсаалтанд бүртгэгдсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж нэн даруй үйл ажиллагаагаа сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна. 2016 онд Засгийн газраас бизнес, аж ахуйн нэгжүүдэд хандан гаргасан мэдэгдэлд, бизнес эрхлэгчид хэн нэгнийг ажилд авах болон гэрээ байгуулахаасаа өмнө Хар жагсаалтанд орсон эсэхийг нягтлахыг зөвлөсөн байна.

Хятадын Засгийн газар хар жагсаалтыг олон янзаар ашигладаг бөгөөд иргэд болон аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийн санг тогтмол шинэчлэн, оноог тооцож байдаг. Төв

засгийн газрын хэмжээнд зангидах үндсэн нэг мэдээллийн систем хараахан бүрдээгүй хэдий ч Хятад улс даяар төрийн байгууллагуудын үйл ажиллагаандаа ашигладаг хэдэн зуун хар жагсаалт байна. Засгийн газрын агентлаг бүр нь өөрийн эрх мэдлийн хүрээнд орон нутгийн салбар байгууллагууддаа өөрийн харьяаллын дагуу үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгжийн хар жагсаалтын бүртгэл хөтлөхийг зөвшөөрдөг байна. Хувь хүн болон аж ахуйн нэгж нь нэг байгууллагын хар жагсаалтад бүртгэгдсэн тохиолдолд орон даяар бусад салбар байгууллагууд руугаа мэдээлдэг байна. Нэгэнт хар жагсаалтад орсон хувь хүн, аж ахуйн нэгжийн хувьд хар жагсаалтаас гарахын тулд 2-5 жилийн хугацаа шаарддаг. Үйл ажиллагаагаа сайжруулаагүй аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авдаг байна.

Нийгмийн оноонд үндэслэн шийтгэл ногдуулах

Тааруу үнэлгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад шийтгэл ногдуулдаг байна. Шийтгэлд аяллын хориг, сургуульд элсэх хориг, ажлын хориг, хяналт, шалгалтыг нэмэгдүүлэх, байгууллага, аж ахуйн нэгжийн алдаа дутагдлыг олон нийтэд зарлах зэрэг багтдаг байна.

Аяллын хориг
Хятадын үндэсний онооны мэдээллийн төв (China’s National Public Credit Information Center)-ийн 2019 оны тайланд дурдсанаар 23 сая хүн нийгмийн оноогоо хасуулсны улмаас онгоц болон галт тэргээр аялах эрхээ хасуулсан байна.

Сургуульд элсэх хориг
Эцэг, эхийнх нь нийгмийн оноонд үндэслэн суралцагсдыг тодорхой их, дээд сургуульд элсүүлэхийг хориглодог байна. Тухайлбал, 2018 онд эцэг нь өрийн хар жагсаалтад орсон гэх шалтгаанаар нэгэн суралцагчийг их сургуульд элсүүлэхээс татгалзсан байна.

Ажлын хориг
Ажил олгогчид ажилтан авахдаа нийгмийн оноог нь харгалзан үзэх болсон байна. Ялангуяа тааруу үнэлгээтэй бол төрийн албанд ажиллах боломжгүй байна.

Хяналт, шалгалтыг нэмэгдүүлэх
Тааруу үнэлгээтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд аудит болон бусад төрлийн хяналт шалгалтыг нэмэгдүүлдэг байна.

Олон нийтэд зарлах
Үйл ажиллагаа нь доголдолтой, нийгмийн оноо тааруу хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд зарладаг байна.

Нийгмийн оноог хасах зүй бус үйлдэл, зөрчлүүдээс дурдвал:

- Эцэг, эхийгээ асралгүй орхих;
- Улаан гэрлээр зам хөндлөн гарах;
- Нохойгоо уяагүй салхилуулах;
- Зөвшөөрөлгүй газар тамхи татах;
- Онлайн видео тоглоомд хууран мэхлэх зэрэг ордог байна.

Нийгмийн оноонд үндэслэн урамшуулах буюу Улаан жагсаалт (Red List)-д бүртгэх

Нийгэмд зөв зүйтэй ажиллаж, амьдарч буй иргэд, байгууллагуудад урамшуулал олгон Улаан жагсаалтад бүртгэдэг байна. Улаан жагсаалтад орсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлөхүйц тодорхой давуу эрхийг олгодог байна. Ажил үйлчилгээгээрээ тэргүүлэгч аж ахуйн нэгжүүдэд олон төрлийн хөнгөлөлт эдлүүлдгээс дурдвал:

- Захиргааны үйл ажиллагааг хялбарчлах – Дэвшилтэт аж ахуйн нэгж (Advanced certificate enterprise) ангилалд багтсан компаниуд нь түргэвчилсэн журмаар гаалийн бүрдүүлэлтэд хамрагдах, А зэрэглэлийн татвар төлөгчид (A rated tax-payers) түргэн хугацаанд татварын буцаан олголтоо хүлээн авах;
- Аудит, хяналт шалгалт цөөрөх;
- Түргэн хугацаанд зөвшөөрлийн эрх авах зэрэг хөнгөлөлтийг эдэлдэг байна.

Нийгмийн онооны системд технологийг хэрхэн ашигладаг тухайд

Нийгмийн онооны системд технологийн дэвшлийг өргөнөөр ашиглаж байна. Хиймэл оюун ухаанаар царай таних программ ашиглан Хятад улс даяар 600 сая гаруй цувраа камер сурилуулан иргэдийг хянаж байна. Тус камеруудын тусламжтайгаар иргэдийн өдөр тутмын амьдралын үйлдэл бүрийг хянаж, зөрчил гаргасан иргэдийг зөрчлийн болон хар жагсаалтад бүртгэдэг байна. Иргэдийн биеийн үйлдлийг хянахын сацуу онлайн үйлдлийг мөн хянадаг байна. Үүнд, засгийн газрын эсрэг аливаа шүүмж бичих, түүнийг хуваалцах зэрэг зөрчлүүд мөн орно. Хяналтын дийлэнх хэсгийг хиймэл оюун ухааныг ашиглан гүйцэтгэж, зөрчил гарсан тохиолдолд хяналтын ажилтнууд бүртгэн авч, эрх бүхий албан тушаалтнуудад мэдээлдэг байна. Технологи улам сайжирч, хиймэл оюун ухаан нь засгийн газрын эсрэг иргэдийн эсэргүүцлийн дүрс бичлэгийг илрүүлэн, олон нийтэд түгэхээс сэргийлэн хаах зэрэг үйлдлийг гүйцэтгэх болсон байна.

Хятадын олон нийтийн аюулгүй байдлын систем болон нийгмийн онооны систем нь тусдаа зүйлс юм. Одоогийн байдлаар хар жагсаалт болон улаан жагсаалтыг гараар түүвэрлэн тэмдэглэж байгаа бөгөөд олон нийтийн аюулгүй байдлын алба болон нийгмийн онооны системийг хараахан нэгтгээгүй байна.

2.2. ХБНГУ

Хятадын нийгмийн онооны систем бол ёс суртахууны зан байдал, санхүүгийн баталгаат байдал болон нийгмийн хяналтыг сайжруулах зорилготой хиймэл оюун ухаанд суурилсан систем бөгөөд нийгмийн инженерчлэлийн хамгийн том оролдлого, томоохон цахим инновацын нэг юм. Энэ системийн үр нөлөө Хятадын хүрээнээс хальж Хятадад үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын компаниуд болон иргэдэд нөлөөлж эхэлсэн байна. Үүний нөлөөгөөр Германы Бавари мужид үйл ажиллагаа явуулж буй Хятадын хөрөнгө оруулалттай компаниудад нэвтэрч эхэлжээ.[1]

Улмаар тус улсад олон нийтийн хяналт (mass surveillance), их өгөгдөл (big data)-ийг хослуулан иргэдийг оноогоор үнэлэх Хятадын системийг сайн дурын үндсэн дээр нэвтрүүлж эхэлсэн. Гэвч нийгмийн онооны энэхүү системийг нэвтрүүлж байгаад иргэд олон нийт, эрдэмтэн, судлаачид шүүмжлэлтэй хандаж байв. Тухайлбал, Берлин дэх “Хүний хөгжлийн Макс Планкийн хүрээлэн”-ийн Эрсдэлийн мэдлэгийг дээшлүүлэх төвийн захирал Герд Гигерензер Handelsblatt-ийн охин компани болох Der Tagesspiegel хэвлэлийн газарт өгсөн ярилцлагандаа: “*Хэрвээ та нийгмийн тогтсон хэв журмыг мөрдөхгүй бол, хэрвээ та үнэлгээ муутай цахим хуудсанд хандалт хийсэн бол, хэрвээ та хэт олон видео тоглоом худалдаж авсан бол, бас улаан гэрлээр зам хөндлөн гарсан, тэр бүү хэл оноо муутай хүмүүстэй нөхөрлөсөн бол нийгмийн оноо чинь навс унана гэсэн үг*” хэмээн

[1] https://www.hfp.tum.de/governance/forschungsprojekte/learning-from-the-frontrunner-a-multidisciplinary-analysis-of-the-chinese-social-credit-system-and-its-impact-on-germany-1/

өгүүлжээ. Тэрээр Германы Хууль зүйн яаманд зөвлөх статустай хэрэглэгчдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн зөвлөлийн тэргүүнээр бас ажилладаг байна.[2]

Мөн "Хэрвээ таны оноо хэт доошилбол үр хүүхдүүд чинь сайн сургуульд орж чадахгүй гэх мэт олон зүйлийн хориг хязгаарлалтанд орох болно" гэж мэргэжилтнүүд анхааруулах болсон.

Энэ мэтчилэн тус улсад нийгмийн онооны систем нь олон нийтийн шүүмжлэлтэй тулгарч, асуудал дагуулсаар байгаа ч аль хэдий нь Шуфа ("SCHUFA") гэх нийтийн онооны системийг хэрэглээд эхэлжээ. Энэ нь АНУ-ын FICO системтэй адил бөгөөд одоогоор Германы 67 сая гаруй иргэн, 5 сая компанийн мэдээллийг агуулсан, зээлдүүлэгч болон бусад зээлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэхэд туслах мэдээллээр хангах үндсэн чиг үүрэг бүхий хувийн компани юм.

Зарим хүмүүс Германы энэхүү систем эдгээр шийдвэрийг бүхэлд нь хувийн компаниуд гаргахыг зөвшөөрснөөр эдгээр оноог бүр ч тодорхой бус болгож байна гэж шүүмжилдэг.

Өөр бусад салбарын хувьд, Германы эрүүл мэндийн даатгалын салбарынхан даатгалын шимтгэлийг бууруулахын тулд фитнессийн мэдээллийг программаар дамжуулан ашигладаг.

Энэ нь иргэд фитнесс клубт явах, биеийн тамираар хичээллэх зэргээр өөрийн эрүүл мэнддээ анхаарч байгаа тохиолдолд илүү таатай шимтгэл ногдуулна гэсэн үг юм. Тухайлбал, иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор фитнесс төвөөр үйлчлүүлэгчдэд "Үнэнч тууштай байдлын оноо" /Loyalty point/-г тооцож, үүнийг харгалзан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулдаг болсон.[3]

"SCHUFA" онооны систем[4]

"SCHUFA" нь банк, зээлийн картын компаниуд, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч, олон нийтийн бүртгэл гэх мэт янз бүрийн эх сурвалжаас хувь хүмүүс болон компаниудын талаарх мэдээллийг цуглуулдаг бөгөөд байр түрээслэх, худалдан авах, зээл авах, зээлээр бараа бүтээгдэхүүн худалдан авахад шаардлагатай тайлан мэдээллийг гаргаж өгдөг.

SCHUFA-ийн үндсэн чиг үүрэг нь хэрэглэгчдийн зээлжих чадвар, санхүүгийн зан үйлийн талаарх мэдээллийг цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх явдал юм.

SCHUFA-ийн мэдээллийн санд дараах зүйлс багтана:

- Нэр, төрсөн огноо, хаяг гэх мэт хувийн мэдээлэл
- Зээл, зээлийн карт болон бусад төрлийн зээлийн дансны дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан зээлийн түүх
- Төлбөрийг хугацаанд нь төлсөн эсэх зэрэг төлбөрийн түүх
- Шүүхийн шийдвэр, дампуурал, битүүмжлэл зэрэг олон нийтийн бүртгэл гэх мэт.

SCHUFA нь энэхүү мэдээллийг зээлийн тайлан, оноог бий болгоход ашигладаг бөгөөд хүсэлтийн дагуу гишүүн компаниуддаа өгдөг байна.

SCHUFA-ийн тайланг дараах тохиолдолд заавал шаарддаг:

1. Зээл хүсэх;
2. Орон сууц түрээслэх;

[2] https://www.thefuturescentre.org/germany-edges-toward-chinese-style-rating-of-citizens/
[3] https://joinhorizons.com/china-social-credit-system-explained/#Are_There_Overseas_Equivalents_to_the_Social_Credit_System
[4] https://www.schufa.de/en/faq/private-individuals/index.jsp

3. Банкны данс нээлгэх;
4. Ажилд орох өргөдөл гаргах: Зарим салбарт ажил олгогчид ажилд авах үйл явцын нэг хэсэг болгон SCHUFA тайланг шаардаж болно. Ялангуяа санхүүгийн хариуцлагатай эсвэл өндөр түвшний итгэлцэл шаарддаг ажилд;
5. Өөрийн зээлийн түүхийг баталгаажуулах: Иргэд зээлийн болон бусад үйлчилгээнд хамрагдаагүй ч SCHUFA тайлангийнхаа хуулбарыг авах нь мэдээлэл үнэн зөв, шинэчлэгдсэн эсэхийг шалгахад тустай. Энэ нь тухайн хүний зээлийн тайлан дээрх аливаа алдаа, залилан мэхлэх үйлдлийг олж илрүүлж, залруулах арга хэмжээ авахад тусалдаг.

Зарим тохиолдолд шаардлагатай SCHUFA тайлангийн төрөл нь нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болно. Жишээлбэл, моргейжийн зээлд хамрагдах бол зээлдүүлэгчийн орлого, ажил эрхлэлтийн түүхийн талаарх мэдээллийг агуулсан илүү дэлгэрэнгүй SCHUFA тайланг шаардаж болно.

Эдгээр бүх мэдээллийг SCHUFA-ийн мэдээллийн санд хувь хүн эсвэл компани бүрийн зээлийн тайланг гаргахад ашигладаг бөгөөд зээлийн тайланд зээлдүүлэгчид боломжит зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэхэд ашигладаг оноог багтаасан байдаг.

SCHUFA оноо нь 0-100 хооронд хэлбэлздэг бөгөөд өндөр оноо нь төлбөрийн чадварын эрсдэл бага байгааг харуулж байна. Тухайлбал,

SCHUFA-ийн онооны түвшин болон зээлийн зэрэглэл[5]

SCHUFA-ийн онооны түвшин	**Зээлийн зэрэглэл**	**Утга**
90-100%	Маш сайн	Энэ нь маш сайн зээлийн үнэлгээ бөгөөд эрсдэл багатайг харуулж байна.
80-89%	Сайн байна	Энэ нь зээлжих зэрэглэл сайн байгаа, эрсдэл харьцангуй бага байгааг харуулж байна.
70-79%	Хангалттай	Энэ хязгаарт оноо авсан хүмүүс хангалттай зээлийн үнэлгээтэй байгаа нь дундаж үзүүлэлт юм.
50-69%	Хангалттай	Энэ нь хангалттай зээлийн үнэлгээтэй байгаа ч зээл эсвэл зээлийн картыг төлөхгүй байх эрсдэл өндөр байгааг харуулж байна.
0-49%	Хангалтгүй	Энэ хязгаарт оноо авсан хүмүүс зээлийн зэрэглэл муу байгаа нь зээл эсвэл зээлийн картыг төлөхгүй байх эрсдэл маш өндөр байгааг харуулж байна.

Зээлийн оноо өндөр байх нь зээлийн хүү буурахад хүргэдэг бол зээлийн оноо бага байх нь зээлийн хүүг нэмэгдүүлэх эсвэл бүр зээлийн хүсэлтээс татгалзахад хүргэдэг. Иймд зээлдэгчид төлбөрөө хугацаанд нь хийж зээлийн оноогоо сайн байлгах нь чухал байдаг.

SCHUFA нь хэрэглэгчдэд зээлийн тайлан, оноотой танилцах, маргаан шийдвэрлэх, хувийн мэдээллийг авах зэрэг үйлчилгээг санал болгодог.

Хэрэглэгчид *Холбооны мэдээлэл хамгаалах тухай хуулийн* дагуу SCHUFA-ийн тайлангийн хуулбарыг жилд нэг удаа үнэгүй авах хүсэлт гарах эрхтэйгээс гадна нэмэлт тайлан эсвэл онооны тайланг төлбөртэйгээр авах боломжтой. Хэрэв хэрэглэгч SCHUFA тайланд алдаатай мэдээлэл байна гэж үзвэл SCHUFA-д гомдол гаргаж, залруулах хүсэлт тавьж болно. SCHUFA нь маргааныг судалж, тодорхой хугацаанд үр дүнг хэрэглэгчдэд мэдэгдэх

[5] https://www.schufa.de/en/scoring-data/scoring-schufa/#561708

ёстой. Хэрэв маргаан хэрэглэгчийн талд шийдэгдсэн бол SCHUFA-ийн тайлангаа зохих ёсоор шинэчлэх үүрэгтэй.

2018 онд Германы шүүхээс SCHUFA-ийн мэдээллийн санд хадгалагдаж буй 3-аас дээш жил болсон сөрөг мэдээллийг SCHUFA устгах ёстой гэсэн шийдвэр гаргасан. Хуучирсан мэдээлэл нь тухайн хүний зээлийн оноо болон зээл авах чадварт шударга бусаар нөлөөлж болзошгүй гэсэн үндэслэлээр уг шийдвэрийг гаргажээ.

Мөн иргэдийн хувийн мэдээлэл нэг дор цахим хэлбэрээр төвлөрсөн нь цахим халдлагад өртөх, устах, мэдээлэл алдагдах зэрэг эрсдэлтэйгээс гадна SCHUFA онооны систем нь хэтэрхий ил тод бус оноогоо хэрхэн тооцдог нь ойлгомжгүй гэх шүүмжлэлийг дагуулж байсан учраас SCHUFA-ийн үйл ажиллагаанд хяналт тавих OpenSchufa санаачилгыг 2018 онд өрнүүлсэн байна.

SCHUFA-ийн үйлчилгээ нь Европын Мэдээллийн хамгаалалтын ерөнхий журам (GDPR) болон Холбооны мэдээллийн хамгаалалтын хууль (BDSG)-ийн хүрээнд явагддаг бөгөөд Мэдээлэл хамгаалах, мэдээллийн эрх чөлөөний асуудал хариуцсан Хессе мужийн Холбооны мэдээлэл хамгаалалт, мэдээллийн эрх чөлөөний комиссын (Hessian Commissioner) хяналтанд байдаг байна.[6]

2.3. ИБУИНХУ

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (Их Британи)-д нийгмийн оноог (Social credit score)[7] Хятад зэрэг зарим улстай адил хэрэгжүүлээгүй байна. Харин санхүүгийн байгууллагуудын зээлийн хүсэлтийг үнэлэхэд ашигладаг зээлийн оноо гэх мэт зээлийн чадварыг үнэлдэг системүүд байдаг. Эдгээр оноо нь зээлийн түүх, эргэн төлөлтийн зан байдал болон бусад санхүүгийн хэмжигдэхүүн зэрэг хүчин зүйлс дээр суурилдаг. Зээлийн оноо нь санхүүгийн шийдвэр гаргах, зээл, орон сууцны зээл, зээлийн картын боломжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн орон сууц түрээслэх, нийтийн үйлчилгээний гэрээ байгуулах гэх мэт тодорхой үйлчилгээнд хамрагдахад нөлөөлдөг. Энэ нь орлого багатай эсхүл нийгмийн халамжаас хамааралтай хүмүүст харьцангуй нөлөөтэй байдаг.

Зээлийн оноо нь тухайн хүний зээлжих чадварын тоон илэрхийлэл бөгөөд зээлдүүлэгчид санхүүгийн найдвартай байдлын талаарх ойлголтыг өгдөг. Зээлийн оноог хэд хэдэн элементүүдийг ашиглан тооцдог бөгөөд зээлийн онооны чухал бүрэлдэхүүн хэсэг нь зээлийн данс, төлбөрийг цаг тухайд нь хийсэн эсэх тухай төлбөрийн түүх, зээлийн ашиглалт, зээлийн данс эзэмшсэн хугацаа буюу зээлийн түүх, ашиглаж буй зээлийн төрлүүд болон шинээр авсан зээлийн мэдээллээс бүрддэг. Зээлжих чадварын үнэлгээ нь санхүүгийн зан үйлээр хязгаарлагддаг бөгөөд нийгмийн зан үйлд хамаарахгүй.

Зээлийн оноог ихэвчлэн тодорхой хязгаарт гурван оронтой тоогоор илэрхийлдэг. Их Британид хамгийн түгээмэл зээлийн онооны хүрээ нь 300-аас 850 хүртэл байдаг бөгөөд үүнийг дараах байдлаар ангилдаг.

- **Муу (300-579):** Энэ хүрээний хүмүүс зээл авахад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд хэрэв зөвшөөрвөл илүү өндөр хүүтэй тулгарах магадлалтай. Энэ нь зээлийн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл өндөр байгааг харуулж байна.
- **Шударга (580-669):** Энэ хүрээнд байгаа хүмүүс зээлд хамрагдах боломжтой хэдий ч өндөр хүүтэй, таатай нөхцөл бага. Санхүүгийн боломжуудыг сайжруулахын тулд зээлийн оноогоо сайжруулах нь зүйтэй.

[6] https://www.schufa.de/en/scoring-data/data-schufa/#563900
[7] https://www.socialcreditscore.co.uk/what-is-my-social-credit-score/

- **Сайн (670-739):** Зээлийн сайн оноо нь төлбөрийн чадваргүй болох эрсдэл багатайг харуулж байгаа бөгөөд энэ хүрээнд байгаа хүмүүсийг өрсөлдөхүйц хүү, таатай нөхцөлөөр хангах боломжтой байдаг. Тэд ерөнхийдөө найдвартай зээлдэгч гэж тооцогддог.
- **Маш сайн (740-799):** Төгс зээлийн оноотой хүмүүс зээлийн бүтээгдэхүүний таатай нөхцөлийг хүлээн авах магадлалтай. Зээлдүүлэгчид тэднийг эрсдэл багатай зээлдэгчид гэж үздэг бөгөөд санхүүгийн өргөн сонголттой болох боломжтой.
- **Маш сайн (800-850):** Маш сайн зээлийн оноо нь зээлийн түүх, санхүүгийн хариуцлагатай байдлыг илэрхийлдэг. Энэ хүрээний хүмүүс ихэвчлэн хамгийн таатай нөхцөлийг хүлээн авч, зээлийн бүтээгдэхүүний хамгийн сайн хүүг эдэлдэг.

Зээлийн оноонд хөдөлмөр эрхлэлтийн түүх, орлогын түвшин, хадгаламж болон хөрөнгө оруулалт, хэрэглээний төлбөр хэмжээ нөлөөлдөггүй байна.

Харин зээлийн оноогоо сайжруулах нь байнгын хүчин чармайлт, хариуцлагатай санхүүгийн зуршил шаарддаг үйл явц юм. Зээлийн оноогоо нэмэгдүүлэхэд туслах тодорхой арга байдаг. Үүнд:

- Төлбөрийг цаг тухайд нь хийх: Таны зээлийн оноонд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг бол төлбөрийн түүх юм.
- Зээлийн картын үлдэгдлийг багасгах: Таны зээлийн хязгаартай харьцуулахад зээлийн картын үлдэгдэл өндөр байгаа нь таны зээлийн оноонд сөргөөр нөлөөлнө.
- Зээлийн багцаа төрөлжүүлэх: Зээлийн карт, хэсэгчилсэн зээл, жижиглэнгийн данс зэрэг өөр өөр төрлийн зээлийн холимог байх нь таны зээлийн оноонд эергээр нөлөөлнө.
- Зээлийн хязгаарыг нэмэгдүүлэх: Одоогийн кредит картандаа зээлийн дээд хязгаарыг хүсэх нь таны зээлийн оноонд тусална.
- Хуучин дансаа хаахаас зайлсхийх: Зээлийн түүхийн урт нь таны зээлийн оноонд нөлөөлдөг.
- Сөрөг зүйлсийг хаяглах: Төлбөр хоцрох, цуглуулах гэх мэт аливаа алдаа эсвэл зээлийн бүртгэлийн муу элементүүдийг шийдвэрлэх.
- Зээлийн онооны санхүүгийн шийдвэрт үзүүлэх нөлөө. Зээлийн оноо нь санхүүгийн янз бүрийн шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Зээлийн оноо өндөр байх нь зээлийн хүү буурах, зээлийн хязгаар нэмэгдэх гэх мэт илүү таатай нөхцөлийг илэрхийлдэг. Их Британид зээлжих чадварын үнэлгээ нь үндсэндээ зээлийн оноонд тулгуурладаг бөгөөд энэ нь тухайн хүний зээлийн түүх, санхүүгийн зан үйлийн тоон үзүүлэлт юм.

Тус улсад нийгмийн онооны албан ёсны тогтолцоо байхгүй ч мэдээллийн аналитик болон дижитал тандалтын хэрэглээ улам бүр нэмэгдэж байгаа нь хувь хүний эрх чөлөө, нийгмийн тэгш байдалд үзүүлэх нөлөөллийн талаар асуудлуудыг бий болгож байна. Тухайлбал, Мэдээллийн нууцлал ба хамгаалалтын асуудал юм. Их Британид мэдээлэл хамгаалах хатуу хуулиуд үйлчилдэг. Европын Мэдээлэл хамгааллын ерөнхий журам (GDPR) болон 2018 оны Мэдээлэл хамгаалах тухай хуулиуд нь хувийн мэдээлэл, түүний дотор санхүүгийн болон зан үйлийн мэдээллийг хэрхэн цуглуулах, хадгалах, ашиглахыг зохицуулдаг. Хувийн нууцыг хамгаалах, ялгаварлан гадуурхалтыг зогсоох, өгөгдлийг буруугаар ашиглахыг зогсоох зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж

- The Social Credit System in a global context https://cadmus.eui.eu/bitstream/handle/1814/60424/LAW_2019_01.pdf?sequence=1&isAllowed=y
- China Social Credit System Explained https://joinhorizons.com/china-social-credit-system-explained/#Are_There_Overseas_Equivalents_to_the_Social_Credit_System
- The Human Rights Implications of China's Social Credit System https://bpb-us-e1.wpmucdn.com/sites.suffolk.edu/dist/5/1153/files/2021/01/Rettinger.pdf
- Human Rights Watch https://www.hrw.org/news/2023/10/09/eu-artificial-intelligence-regulation-should-ban-social-scoring
- EU: Artificial Intelligence Regulation Should Ban Social Scoring https://www.hrw.org/news/2023/10/09/eu-artificial-intelligence-regulation-should-ban-social-scoring
- How's your social credit score? https://www.hult.edu/blog/your-social-credit-score/
- Coming soon: America's own social credit system https://thehill.com/opinion/finance/565860-coming-soon-americas-own-social-credit-system/
- Social credit: The next China risk for Australian business https://www.lowyinstitute.org/the-interpreter/social-credit-next-china-risk-australian-business
- Equal Credit Opportunity Act https://www.justice.gov/crt/equal-credit-opportunity-act-3
- https://www.kaspersky.com/blog/social-scoring-systems/
- https://www.thefuturescentre.org/germany-edges-toward-chinese-style-rating-of-citizens/
- https://joinhorizons.com/china-social-credit-system-explained/#Are_There_Overseas_Equivalents_to_the_Social_Credit_System
- https://www.schufa.de/en/index.jsp
- https://www.signicat.com/registry-methods/schufa
- https://hallogermany.com/blog/schufa-for-free
- https://algorithmwatch.org/en/personal-scoring-in-the-eu-not-quite-black-mirror-yet-at-least-if-youre-rich/
- https://handbookgermany.de/en?gad_source=1&gclid=EAIaIQobChMIvICT2OOoiAMVjddMAh0ByTAgEAMYASAAEgI5IfD_BwE
- https://www.ssa.gov/policy/docs/progdesc/ssptw/2018-2019/europe/germany.html
- https://www.sciencedirect.com/science/article/pii/S2211335519300191#s0020
- https://www.cambridge.org/core/journals/asian-journal-of-law-and-society/article/algorithmic-credit-scoring-in-vietnam-a-legal-proposal-for-maximizing-benefits-and-minimizing-risks/332A14670E7C75746E1A3F9B6AD09E4F
- https://www.hfp.tum.de/governance/forschungsprojekte/learning-from-the-frontrunner-a-multidisciplinary-analysis-of-the-chinese-social-credit-system-and-its-impact-on-germany-1/
- Social credit score https://www.socialcreditscore.co.uk/will-labour-bring-in-a-social-credit-score-system/
- https://rah.co.uk/what-is-a-credit-score-and-how-does-it-work/